



ДУНДГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 68

Мандалговь

Г Үл хөдлөх хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалтыг 6.2.1, 6.4 дэх заалтыг 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Өндөршил сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2018 оны 13-07-016/89 дүгээр дүгнэлтээр цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон нь тогтоогдсон 1,684,474 /нэг сая зургаан зуун наян дөрвөн мянга дөрвөн зуун далан дөрөв/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй хавсралтад дурдсан нэг айлын орон сууцыг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

Хоёр. Өндөршил сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал (Н.Дэлгэрсайхан)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

- 2.1 Сумын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийг акталж, данснаас хасах, акталснаас гарах материалыг борлуулж, ажлын хөлсөнд зарцуулахыг дурдсугай.
- 2.2 Үл хөдлөх хөрөнгийг акталж, чөлөөлсөн газрыг нөхөн сэргээж байгууллагын хэрэгцээнд зориулалтаар нь ашиглах.
- 2.3 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх.
- 2.4 Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 08 дүгээр сарын
28-ний өдрийн 68 тогтоолын хавсралт

Өндөршил сумын Ерөнхий боловсролын сургуулийн акталж, данснаас хасах барилгын мэдээлэл

№	Барилга, байгууламжийн нэр	зориулалт	Хэмжих нэгж		Ашиглалтад орсон огноо	Ашиглалтын нийт хугацаа /жилээр/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			Хэмжих нэгж	Биет хэмжээ					
1	Нэг айлын орон сууц	Орон сууц	M2	105	1965-01-01	60	1,684,474	1,684,474	
Нийт дүн									
							1,684,474 /нэг сая зургаан зуун наян дөрвөн мянга дөрвөн зуун далан дөрөв/	1,684,474 /нэг сая зургаан зуун наян дөрвөн мянга дөрвөн зуун далан дөрөв/	